



## ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

### Тамсаг-XXI талбайн нөөц бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны 01/12 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Тамсаг-XXI талбайд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн гүйцэтгэсэн хайгуулын ажлын мэдээллүүдийг үндэслэн АНУ-ын D&M (DeGolyer and MagNaughton) компани 2011 оны 04 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд Тамсагийн ордын 21-25, 21-35-36, 21-25-1, 21-59-2, 21-79, 21-35, 21-70, 21-18, 21-38, 21-61, 21-54/55/9/67, 21-33, 21-63 блокуудын баталгаат зэрэглэлийн нөөцийг 127.509 сая тонноор, үүнээс байгалийн горимоор ашиглах ашиглалтын баталгаат нөөцийг 14.010 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах ашиглалтын баталгаат нөөцийг 21.018 сая тонн, туршилтын олборлолтыг хасаад үлдсэн ашиглалтын баталгаат нөөцийг 14.009 сая тонн (байгалийн горимоор), 21.017 сая тонноор (ус шахалтын горимоор),

-Тамсагийн газрын тосны ордын 21-25, 21-35-36, 21-25-1, 21-59-2, 21-79, 21-35, 21-70, 21-18, 21-38, 21-61, 21-54/55/9/67, 21-33, 21-63 блокуудын баталгаат+магадтай зэрэглэлийн нөөц 137.770 сая тонн, үүнээс ашиглалтын магадтай нөөц 3.145 сая тонноор.

-Тамсагийн газрын тосны ордын 21-25, 21-35-36, 21-25-1, 21-59-2, 21-79, 21-35, 21-70, 21-18, 21-38, 21-61, 21-54/55/9/67, 21-33, 21-63 блокуудын баталгаат+магадтай+боломжит зэрэглэлийн нөөцийг 145.614 сая тонн, үүнээс ашиглалтын боломжит зэрэглэлийн нөөц (ус шахалтын горимоор) 6.340 сая тонноор (хавсралт 1, 2, 3) Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд тус тус бүртгэхийг Ашигт малтмалын газар /даргын үүрэг гүйцэтгэгч М.Ариунбаяр/-т даалгасугай.

Хоёр.Монгол Улс болон БНХАУ-ын хил дамнасан Т21-35 блок, мөн Т21-35 блокын баруун хойд талд өрөмдсөн Т21-58 дугаартай цооног бүхий талбайнуудад Олон улсад мөрдөгдөж байгаа газрын тосны холбогдох хуулийн хүрээнд хоёр талын ажлын хэсэг байгуулж, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах ажлыг шийдвэрлэхийг Түлшний бодлогын газар /А.Эрдэнэпүрэв/ -т даалгасугай.

Гурав.Ашиглалт эхэлсэнээс хойш жил бүр олборлосон газрын тосны хэмжээг тооцож нөөцийн хөдөлгөөн хийж зохих журмын дагуу Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд бүртгүүлж байхыг Газрын тосны газар /түр орлон гүйцэтгэгч П.Сарангэрэл/ болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалгасугай.


0800210



Дөрөв.Тамсаг-XXI талбайн олборлолтыг нэмэгдүүлэх аргуудыг хэрэглэснээр өсөх ашиглалтын нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр тухай бүр хэлэлцүүлж, зохих журмын дагуу Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд бүртгүүлж байхыг Газрын тосны газар /түр орлон гүйцэтгэгч П.Сарангэрэл/ болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалгасугай.

Тав.Тамсаг-XXI талбайд АНУ-ын D&M компанийн боловсруулсан нөөцийн тооцооны тайланг зохих журмын дагуу дахин боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдааны 2012 оны 01/12 дүгнэлт, энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш 6 сарын дотор Газрын тосны газарт болон Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд тус тус хүлээлгэн өгөхийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалгасугай.

Зургаа.Монгол Улсын “Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 15 дугаар зүйлийн 1, 3 дахь заалт, Тамсаг-XXI талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний 5.4 дүгээр заалтын “б” хэсэг, 8.5 дугаар заалтын дагуу Тамсагийн газрын тосны ордыг ашиглах төлөвлөгөөг баталгаат зэрэглэлийн нөөцөд тулгуурлан боловсруулж, Газрын тосны газраар батлуулахыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д даалгасугай.

Долоо.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Түлшний бодлогын газар /А.Эрдэнэпүрэв/, Газрын тосны газар /түр орлон гүйцэтгэгч П.Сарангэрэл/-т, Ашигт малтмалын газар /даргын үүрэг гүйцэтгэгч М.Ариунбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД  Д.ЗОРИГТ



Эрхэс бэлтгэг, эрчим хүчний саяадын  
2012 оны бүтээгдээлээр гарын баримт  
дугаар тухайнхны 1 дугаар хэсэгээр

ТАМГАЙН ГАЗРЫН ТӨСӨН ОРДЫН БАТАЛГААТ ЗЭРГЭЛЛИЙН НӨӨЦЛИЙН ТООЦОО

Болом №	Та 21- 25	Та 21- 35/36	Ашигт үе I			Ашигт үе II			Ашигт үе III			Та 21-70	Та 21-18	Та 21-38	Та 21-41	Та 21-54/55/59/ 67	Та 21-83
			К, зб <sup>а</sup> ,	К, зб <sup>б</sup> ,	К, зб <sup>г</sup> ,	К, зб <sup>а</sup> ,	К, зб <sup>б</sup> ,	К, зб <sup>г</sup> ,	К, зб <sup>а</sup> ,	К, зб <sup>б</sup> ,	К, зб <sup>г</sup> ,						
Формац:																	
Улагдсан арга	ЭЗЭЛЭХҮҮН																
Талбай, м <sup>2</sup>	0.4	51.9	1.9	4.1	2.1	3.0	0.7	1.5	0.5	1.0	4.4	0.3	0.8				
Төстэй үеийн зурвас, м	10.3	27.5	36.7	13.9	26.6	19.5	22.6	12.1	5.8	25.6	17	11	6.4				
азалхуун, 10 <sup>3</sup> м <sup>3</sup>	4.1	1.427.7	09.8	96.9	96.2	98.4	15.8	18.2	2.9	25.6	74.9	3.3	5.1				
Нөц, сая тонн	0.185	101.686	4.356	5.62	5.234	4.211	0.813	1.114	0.198	1.112	2.088	0.108	1.36	127.509			
Ашиглалтын итгэлцүүр (байгалийн горимсоор) %	11.0	11.0	11.0	12.0	12.0	11.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0				
Ашиглалтын нөц, байгалийн горимсоор, сая тонн	0.02	11.185	0.479	0.674	0.628	0.463	0.0731	0.10	0.014	0.10	0.242	0.018	0.012	14.01			
Улдсан ашиглалтын нөц, сая тонн	0.02	11.184	0.479	0.674	0.628	0.463	0.0731	0.10	0.014	0.10	0.242	0.018	0.012	14.009			
Ашиглалтын итгэлцүүр (ус шалхтын горимсоор) %	17	16.8	17	17	17	17	10	10	10	10	10	10	10				
нөц, (ус шалхтын горимсоор) сая тонн-р	0.03 1	17.083	0.741	0.944	0.89	0.707	0.081	0.1114	0.018	0.111	0.269	0.02	0.014	21.018			
Туриштын огноогийн хэмжээ, сая тонн	0	0.081	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0.081			
Улдсан ашиглалтын нөц, сая тонн	0.031	17.682	0.741	0.944	0.89	0.707	0.081	0.111	0.016	0.111	0.269	0.02	0.014	21.017			

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын  
2012 оны 08 дүгээр сарын 16-ны өдрийн  
97 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ТАМСАГИЙН ГАЗРЫН ТОСНЫ ОРДЫН БАТАЛГААТ+МАГАДТАЙ ЗЭРЭГЛЭЛИЙН НӨӨЦИЙН ТООЦОО

Блокын №	T21-35										T21-54					Т21-63	Нийт
	T21-25	T21-35/36	T21-25-1	T21-59-2	T21-79	T21-35	T21-70	T21-18	T21-38	T21-61	T21-54/55/9/67	T21-33					
Дэд блокууд																	
Баталгаат+магадтай нөөцийн талбай, км <sup>2</sup>	1.30	57.00	2.30	4.30	2.70	3.00	0.70	2.10	1.40	2.00	12.10	0.70	1.20				
Тостой үеийн ашигтай зузаан, м	8.2	25.7	33.3	13.3	23.5	19.5	22.6	9.5	4.4	22.3	19.3	9.4	6.3				
Баталгаат+магадтай нөөц, сая тонн,	0.483	104.456	4.648	5.63	5.914	4.211	0.813	1.224	0.334	1.938	7.522	0.395	0.202				13.777
Ашиглалтын итгэлцүүр, ус шахалтын горимоор,%	19.0	18.0	19.0	18.0	19.0	18.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0				
Баталгаат+магадтай нөөцөөс ус шахалтын горимоор ашиглах нөөц, сая тонн	0.092	18.8	0.8831	1.0134	1.124	0.758	0.098	0.147	0.04	0.233	0.903	0.047	0.024				24.162
Ус шахалтын горимоор ашиглах магадтай нөөц, сая тонн	0.061	1.718	0.143	0.069	0.234	0.051	0.017	0.035	0.024	0.121	0.634	0.028	0.011				3.145

